



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/410

Арвайхээр


Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 61 дүгээр зөвлөмжийн дагуу Тарагт сумын Эрүүл мэндийн төвийн засвар, тоног төхөөрөмжийн ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах (ӨВАОНӨГ/201905042) тендерийг хүчингүй болгосугай.

2. Тендер шалгаруулалтанд нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100678